

# Сургаал ба Гэрээ 130-аас үнэнийг заах

## Хичээлийн бэлтгэл:

1-р алхам: Доорх судлах сэдвүүдээс нэгийг сонгоод, өгсөн эх сурвалжуудыг судал. Уншиж буй зүйлийнхээ талаарх Ариун Сүнснээс ирсэн бодол, санаа, сэтгэгдэлд анхаарлаа төвлөрүүл. Мөн та сонгосон сэдвийнхээ тухай ойлголтоо гүнзгийрүүлэх өөр эх сурвалжийг олж болно.

2-р алхам: Сонгосон сэдвээрээ таваас долоон минутын хичээлийн тойм бэлд. Дараах асуултуудын заримыг тоймоо бэлдэхэд туслуулахаар ашигла.

- Эдгээр үнэн нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой харилцах бидний харилцаанд хэрхэн нөлөөлж чадах вэ?
- Би энэ сэдвийг илүү сайн ойлгоход нь бусдад туслахын тулд судрууд болон бошиглогчдын үгсийг хэрхэн ашиглаж болох вэ?
- Би бусдыг хичээлд оролцож, идэвхтэй байлгахад хэрхэн тусалж болох вэ?
- Би ямар туршлагаа хуваалцаж, юуг гэрчилж болох вэ?
- Энэ сэдвийг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь бусдад туслахын тулд би юу хийж чадах вэ?

## Судлах сэдэв ба эх сурвалж:

### 1-Р СОНГОЛТ: МЭДЛЭГ, ОЮУН БИЛИГ АМИЛУУЛАЛТААР БИДЭНТЭЙ ХАМТ СЭРГЭЭГДЭХ БОЛНО.

#### Судлах эх сурвалж

Сургаал ба Гэрээ 130:18–19, Сургаал ба Гэрээ 88:118; 93:36-г тус тус үзнэ үү.

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл А.Максвэлл (1926–2004) ийн заасан.



Хэрэв бид амилуулалтад бидэнтэй хамт юу сэргээгдэх талаар тунгаан бодвол бидний оюун билиг бидэнтэй хамт сэргээгдэх болно гэдгийг тодорхой мэдэх болно. Энэ нь зөвхөн бидний оюуны чадварыг биш үнэнийг хүлээн авч, хэрэгжүүлэх бидний чадварыг мөн хэлдэг. Бидний ур чадвар, зан чанар, авьяас билиг бидэнтэй хамт сэргээгдэнэ. Мөн бидний суралцах чадвар, хувийн сахилга бат, хөдөлмөрлөх чадвар сэргээгдэх нь гарцаагүй. (Neal A. Maxwell, *We Will Prove Them Herewith* [1982], 12)

### 2-Р СОНГОЛТ: БИД БУРХАНЫ ХУУЛИУДЫГ ДАГАСНААР ТҮҮНЭЭС АДИСЛАЛУУДЫГ ХҮЛЭЭН АВДАГ.

#### Судлах эх сурвалж

Сургаал ба Гэрээ 130:20–21-ийг мөн Иохан 7:17; Сургаал ба Гэрээ 82:10-ыг үзнэ үү.

Ерөнхийлөгч Рассэлл М.Нэлсон ийн заасан.



Хэрэв та тодорхой нэгэн адислалыг үнэхээр хүсэж байгаа бол тэр адислалыг захирдаг ямар хуулиуд байгааг олж мэдээд, дараа нь тэдгээр хуульд дуулгавартай болох тал дээрээ ажилласан нь дээр. (Russell M. Nelson, "The Mission and Ministry of the Savior: A Discussion with Elder Russell M. Nelson," *Ensign*, June 2005, 19)